

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ
НЭГДСЭН ТӨСВИЙН
ТӨСӨЛД ӨГСӨН АУДИТЫН
ДҮГНЭЛТ**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ 2021 ᠣᠨᠢ
ᠨᠡᠭᠳᠤᠰᠡᠨ ᠲᠥᠰᠪᠢᠶᠢᠨ
ᠲᠥᠰᠥᠯᠳᠦ Өᠭᠰᠥᠨ ᠠᠤᠳᠢᠲᠢᠶᠢᠨ
ᠳᠦᠭᠨᠡᠯᠲᠤ

 Үндэсний аудитын газар
/Засгийн газрын IV байр/

 www.audit.mn

 info@audit.gov.mn

 (+976) 62-263230

 (+976) 62-263230



2020 он



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

2020.10.14 № 2940
танай _____-ны № _____-т

Аудитын дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 болон Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7-д заасны дагуу Үндэсний аудитын газраас Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн төслийн талаарх дүгнэлтийг хавсралтаар хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт . . . хуудастай.

Хүндэтгэсэн,



Д.ЗАНДАНБАТ

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	3
НЭГ. ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГА, ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ.....	4
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖ	6
ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛ....	8
ДӨРӨВ. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, КОНЦЕСС.....	8
ТАВ. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН	11
ЗУРГАА. НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ	12
ДОЛОО. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГА.....	12
ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ	14
ХАВСРАЛТ	15

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БХС	Батлан хамгаалахын сайд
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГХЭГД	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
МУЕС	Монгол Улсын Ерөнхий сайд
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УЕП	Улсын Ерөнхий прокурор
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ЭХС	Эрчим хүчний сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн төсөлд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн...төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, Улсын Их Хурал...-д хүргүүлэх” гэж заасны дагуу Үндэсний аудитын газар дүгнэлт гаргалаа.

Энэхүү дүгнэлтийг гаргахдаа Төсвийн тогтвортой байдлын тухай, Төсвийн тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай, Нийгмийн даатгалын сангийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн тухай, Ирээдүйн өв сангийн тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай зэрэг хуулиудын холбогдох зүйл, заалт, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их хурлын 2020 оны 23 дугаар тогтоол, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоол зэрэг холбогдох эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгов. Тухайлбал:

1. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төсвийн тусгай шаардлага, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай хуульд заасан төсвийн хүрээний мэдэгдлийг хангасан эсэх;
2. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан зорилт, арга хэмжээтэй уялдсан эсэх;
3. Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт нь төсөвлөлтийн шаардлагад нийцсэн эсэх.

Засгийн газраас төсвийн тогтвортой байдлыг хангах, экспортыг нэмэгдүүлж, баялгаас орох орлогыг бүрэн хураах, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагааны түвшнийг нэмэгдүүлэх, төсвийн орлогын боломжит эх үүсвэрийг дайчлах, эрүүл мэнд, боловсролын салбарт урсгал зардлын шинэчлэлийг эхлүүлэх, коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын үед иргэдийн орлогыг хамгаалж, нийгмийн эмзэг бүлэгт чиглүүлэх, гадаад бондын эргэн төлөлтийг төсөвт дарамт учруулахгүйгээр өрийн менежмент хийх зэрэг бодлогыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 2021 оны төсвийн төслийг боловсруулсан байна.

Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 11,797.8 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүн /цаашид ДНБ гэх/-ий 27.9 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн хэмжээг 13,951.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 33.0 хувь, тэнцвэржүүлсэн тэнцлийг 2,153.7 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 5.1 хувьтай тэнцэхээр төсвийн төсөлд тусгажээ.

НЭГ. ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГА, ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ

1.1 Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага, 2021 оны Төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлж төлөвлөсөн эсэхэд дараах дүгнэлтийг өгч байна.

Хүснэгт 1. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг хангасан байдал

№	Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага	Төсвийн төсөлд тусгагдсан байдал	Хангагдсан эсэх
1	6 дугаар зүйл: 6.1.1. “нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх”	2021 онд зэсийн баяжмал, нүүрснээс төсөвт төвлөрөх орлогын хэмжээ нэгдсэн төсвийн орлогын 3.0-аас дээш хувийг бүрдүүлэхээр байгаа тул хуульд заасны дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байна. Нэг тонн зэсийн тэнцвэржүүлсэн үнийг 5,456.1 ам.доллар, нэг тонн нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг 76.3 ам.доллароор тооцжээ.	Зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцож, төсөвт төвлөрүүлэх нийт 2,804.7 тэрбум төгрөгийн орлого нэгдсэн төсвийн орлогын 21.4 хувийг эзэлж байгаа нь шаардлагыг хангаж байна.
2	6 дугаар зүйл: 6.1.2. “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн ДНБ-ий хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх” гэсэн заалтад 19 дүгээр зүйлийн 19.9-т “... 2020 онд 5.1 хувиас, 2021 онд 3.6 хувиас, ... тус тус хэтрүүлэхгүй, ...”, 2020 онд баталсан Төсвийн зарим тусгай шаардлагын үйлчлэлийг түр түдгэлзүүлэх, мөрдөх хугацааг хойшлуулах тухай хуулийн 2 дугаар зүйлд “Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-д эзлэх хувь хэмжээг мөрдөх хугацааг ... 19.9-т “2020” гэснийг “2021” гэж, “2021” гэснийг “2022” гэж, ... гэж тус тус өөрчлөлт оруулсан байна.	Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2,153.7 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөсөн нь ДНБ (42,230.1 тэрбум төгрөг)-ий 5.1 хувьтай тэнцэж байна.	Нэгдсэн төсвийн төсөлд нийт тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал ДНБ-ий 5.1 хувьтай тэнцүү байгаа нь шаардлагыг хангаж байна.
3	6 дугаар зүйл: 6.1.3. “тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн	2021 оны төсвийн төсөлд нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээ 4.3 хувиар буурсан байна. Эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлт 2021	Нэгдсэн төсвийн нийт зарлага өмнөх оноос 4.3 хувиар буурсан нь шаардлагыг хангаж байна.

	хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх”	онд 7.9 хувьтай, 2009-2020 оны эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дундаж 16.7 хувьтай тус тус тэнцэж байна.	
4	6 дугаар зүйл: 6.1.4. “Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-ий 60 хувиас хэтрэхгүй байх”, 19 дүгээр зүйлийн 19.3-т “Энэ хуулийн 6.1.4-т ... 2020 онд ДНБ-ий 70 хувиас, 2021 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас тус тус хэтрүүлэхгүй байна”, 2020 онд баталсан Төсвийн зарим тусгай шаардлагын үйлчлэлийг түр түдгэлзүүлэх, мөрдөх хугацааг хойшлуулах тухай хуулийн 2 дугаар зүйлд “... 19.3-т “2020” гэснийг “2021” гэж, “2021” гэснийг “2022” гэж хойшлуулан мөрдөнө.” гэсэн өөрчлөлт орсон.	Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл 26,140.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 61.9 хувь байхаар тооцсон байна.	Нэгдсэн төсвийн төсөлд Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл ДНБ-ий 61.9 хувьтай тэнцүү байгаа нь хуульд заасан Засгийн газрын өрийн үлдэгдлийн тусгай шаардлагыг хангаж байна.

Эх сурвалж: Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2021 оны төсвийн тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Дүгнэлт

- Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан тусгай шаардлагуудыг хангаж байна.

Хүснэгт 2. Төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлсэн байдал

Д/Д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл /2020.08.28 баталсан/	2021 оны Төсвийн төсөл	Өөрчлөлт
1	ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ /хувь/	7.2	7.2	0.0
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	7.0	7.0	0.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/ ДНБ-д эзлэх хувь	11,797.8 27.9	11,797.8 27.9	0.0 0.0
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/ ДНБ-д эзлэх хувь	13,951.6 33.0	13,951.6 33.0	0.0 0.0
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/ ДНБ-д эзлэх хувь	-625.9 -1.5	-625.9 -1.5	0.0 0.0
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/ ДНБ-д эзлэх хувь	-2,153.7 -5.1	-2,153.7 -5.1	0.0 0.0
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/ ДНБ-д эзлэх хувь	3,647.2 8.6	3,498.5 8.3	-148.7 -0.3

8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	26,140.5	26,140.5	0.0
	ДНБ-д эзлэх хувь	61.9	61.9	0.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	824.1	1,390.3	566.2
	ДНБ-д эзлэх хувь	2.0	3.3	1.3

Эх сурвалж: Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, 2020.08.28-нд баталсан 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөлөл

1.2 Улсын Их Хурлаас 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай хуульд заасан хэмжээнээс нийгмийн халамжийн зардлыг 566.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр, хөрөнгийн зардлыг 148.7 тэрбум төгрөгөөр бууруулахаар хуулийн төслийг боловсруулсан байна.

Дүгнэлт

- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахдаа Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай хуульд заасан нийгмийн халамжийн болон хөрөнгө оруулалтын зардлын дүнг өөрчилсөн боловч орлого, зарлага, алдагдал, Засгийн газрын өрийн хэмжээг нэмэгдүүлэхгүй тооцсон байна. Цаашид жилийн төсвийн төслийг боловсруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд бүрэн нийцүүлж байх нь зүйтэй байна.
- Төсвийн төсөлд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг оны эхний хагас жилд 100.0 мянган төгрөгөөр тооцож олгохоор төлөвлөсөн нь нийгмийн халамжийн зардлыг төсвийн хүрээний мэдэгдлээс нэмэгдүүлсэн байна.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖ

2.1 Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн төсөлд татварын хувь хэмжээг нэмэгдүүлэхгүй, гаалийн шинэчлэлийг үргэлжлүүлж, баялгаас орох орлогыг бүрэн хураах, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагааны түвшнийг нэмэгдүүлэн, орлогын боломжит эх үүсвэрийг дайчлах бодлогыг хэрэгжүүлснээр нийт орлого ба тусламжийн дүнг 13,134.0 тэрбум, тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийг 11,797.8 тэрбум төгрөг байхаар төлөвлөсний 91.2 хувийг татварын орлогоос, 8.8 хувийг татварын бус орлогоос бүрдүүлэхээр тооцжээ.

2.2 Татварын орлого 2020 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 648.0 тэрбум төгрөгөөр тасрахаар байгаа ба орлогын тасалдлын 45.8 хувийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, 16.2 хувийг гаалийн албан татвар, 16.1 хувийг суутган татварын орлого, 15.5 хувийг НӨАТ, 6.4 хувийг бусад татвар, төлбөр хураамж эзэлж байна.

2.3 Төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 2019 оны гүйцэтгэлээс 892.3 тэрбум, 2020 оны төсвөөс 2,066.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж төсөвлөсөн нь гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр төсвийн орлогын гүйцэтгэлд эрсдэл үүсэж болзошгүй байна.

2.4 Дэлхийн улс орнуудад тархаад буй цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан зарим тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийн хугацаанд өөрчлөлт орсонтой холбогдуулан гаалийн шинэчлэлийн хүрээнд хийж буй хөрөнгө оруулалтын явц 74.0 хувьтай байгаа бөгөөд шинэчлэлийн ажлыг 2021-2022 онд дуусгахаар төлөвлөсөн байна.

2.5 Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн төсөлд зарим эх үүсвэрийг дайчлан орлого нэмэгдүүлэх боломж байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тендерт шалгарсан аж ахуйн нэгжүүдийн гүйцэтгэсэн бараа, ажил үйлчилгээний орлогод ногдох НӨАТ-ын ногдуулалтыг татварын цахим төлбөрийн баримтын системд бүрэн холбох шаардлагатай байна.
- Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар 2018 онд 147.1 тэрбум, 2019 онд 191.4 тэрбум төгрөгөөр ногдол ашгийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг алдаж, төсөвт төвлөрүүлээгүй зөрчил илрүүлсэн. Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 60 аж ахуйн нэгж 1,986.7 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байтал Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 53 аж ахуйн нэгжээс 173.7 тэрбум төгрөгийн ногдол ашиг төвлөрүүлэхээр тогтоосон нь дунджаар 124.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх боломж алдсан байна. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн удирдлага, менежментийг сайжруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газраас хэрэгжүүлэх арга хэмжээг оны эхнээс эхлүүлэх нь зүйтэй байна.
- Монгол Улсын хэмжээнд газрын бүртгэл, мэдээллийг цахимжуулах, ил тод болгох ажлыг эхлүүлсэн боловч хэрэгжилт хангалтгүй, ажил удааширнаас шалтгаалан төсөвт 110.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх боломж алдсан байна. Иймд газрын бүртгэлийг цахимжуулах ажлыг 2020 онд багтаан дуусгах, 2021 оноос эхлэн газрын төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэхэд анхаарах шаардлагатай байна.
- Үйл ажиллагаа эрхэлж буй 10552 төрийн бус байгууллагын нийт мөнгөн орлого 1,257.8 тэрбум төгрөг байгаа нь Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн орлогын 10.4 хувьтай тэнцэж байна. Үүнээс 1700 төрийн бус байгууллага 50.0 саяас дээш төгрөгийн үйл ажиллагааны орлого тайлагнасан боловч 57 байгууллага НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлж, 28 байгууллага 0.6 тэрбум төгрөгийн НӨАТ төлжээ.
- Нэмэлт төсвийн дансанд төвлөрсөн үйл ажиллагааны давсан орлогоос 2017 онд 3.2 тэрбум, 2018 онд 6.2 тэрбум, 2019 онд 13.6 тэрбум төгрөгийг буцаан олгожээ.
- Аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд 2018 онд 487.0 тэрбум, 2019 онд 522.3 тэрбум төгрөгийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн байна. Улсын Их Хурлаас 2019 онд баталсан татварын хуулийн шинэчлэлийн нөлөөгөөр татварын хөнгөлөлт, чөлөөлөлт өмнөх оноос 4.1 хувиар нэмэгдэж 595.0 тэрбум төгрөгт хүрэхээр тооцжээ.
- Улаанбаатар хотын замын ачаалал, түгжрэлийг бууруулахад суудлын автомашины онцгой албан татвар, автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хэмжээг оновчтой тогтоох чиглэлээр холбогдох тооцоо судалгааг хийж, тодорхой арга хэмжээ авах шаардлагатай байна.
- Нүүрсний экспортын хэмжээг 2019 оны гүйцэтгэлээс 14.4 хувиар өндөр буюу 42.0 сая тонн нүүрс экспортлохоор төлөвлөсөн нь борлуулалтын тоо хэмжээ биелэгдэхгүй байх эрсдэлтэй байгаа тул экспортыг нэмэгдүүлэхэд холбогдох яам, агентлаг, орон нутаг дахь төрийн байгууллагуудын ажлын уялдааг сайжруулж, тодорхой арга хэмжээг оны эхнээс хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Дүгнэлт

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд төрийн худалдан авалтаас олсон орлогоо үнэн зөв тайлагнасан, татварт бүрэн хамрагдсан эсэхэд тавих хяналтыг сайжруулж татварын орлогыг нэмэгдүүлэх боломж байна.

- Төрийн бус байгууллагуудыг татварын цахим төлбөрийн баримтын системд хамруулан НӨАТ суутган төлөгчийн бүртгэл, тайлагнал, төлөлтөд тавих хяналтыг сайжруулж, татварын орлогыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.
- Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээс төвлөрүүлэх ногдол ашгийг 100.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.

ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛ

3.1 Нэгдсэн төсвийн 2021 оны нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 13,951.6 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь 2020 оны төсвөөс 625.9 тэрбум төгрөгөөр буюу 4.3 хувиар бууруулан тооцжээ.

3.2 Цэвэр зээлийг хассан нийт зарлагын 75.9 хувийг урсгал зардал, 24.1 хувийг хөрөнгийн зардал эзэлж байна.

3.3 Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлагын дүнд эзлэх урсгал зардал сүүлийн 8 жилийн дунджаар 74.0 хувиас буурахгүй байгаа нь төсвийн зардалд идэвхгүй хэрэглээ зонхилсон, төсвийн бүтэц оновчтой бус, төсвийн удирдлагын бодлогыг сайжруулах шаардлагатай байна.

3.4 Урсгал зардлын 2015-2019 оны төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулахад дунджаар бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 17.0 хувь, бараа үйлчилгээний зардлыг 11.8 хувь, томилолт, зочны зардлыг 8.1 хувь, байр ашиглахтай холбоотой зардлыг 4.2 хувиар тус тус дутуу зарцуулсан нь төсвийн захирагчид төсвийг төлөвлөхдөө тогтоосон тариф, үнэ, норм нормативыг баримталдаггүй, үндэслэлгүй тооцож байгааг харуулж байна.

Дүгнэлт

- Төсвийн орлого бүрдэхэд хүндрэлтэй, гадаад өр төлөхөөр байгаа үед эрүүл мэнд, боловсрол, онцгой байдал, цагдаа, хил, гааль, мэргэжлийн хяналт зэрэг байгууллагуудаас бусад байгууллагын эд хогшил, тээвэр шатахуун, томилолт, зочин төлөөлөгчийн зардал зэрэг зарим төсөв захирагчдын тэвчиж болох зардлуудыг 20 хүртэл хувиар бууруулах шаардлагатай байна.
- Суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтнуудыг цөөлөх, төсвийн байгууллагуудын автотээврийн хэрэгслийн нэгдсэн бүртгэлийг цахимжуулж, хяналтыг сайжруулан, ашиглалтын журмыг шинэчлэх шаардлагатай байна.

ДӨРӨВ. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, КОНЦЕСС

4.1 Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн төсөлд 21 ТЕЗ-ийн төсвийн багцад 3,691.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1,388.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй хөрөнгө оруулалтын 1031 төсөл, арга хэмжээ төсөвлөгдсөнөөс 37.7 хувь буюу 389 төсөл, арга хэмжээ шинээр, 62.3 хувь буюу 642 төсөл, арга хэмжээ үргэлжлэн хэрэгжихээр байна.

4.2 Хөгжлийн дунд хугацааны бодлогын баримт бичиг болох “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хавсралтаар Улсын Их Хурал батлахаар Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2-т заасантай Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8-д “...Засгийн газар улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг дөрвөн жилд нэг удаа баталж...” гэж заасныг нийцүүлэх шаардлагатай байна.

4.3 Монгол Улсын 2021 оны төсвийн төсөлд магадлалаар баталгаажуулсан зураг төсөвтэй байх шаардлагатай төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх 196 барилга, байгууламжийг төлөвлөснөөс Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасныг зөрчиж зураг төсвийг батлуулаагүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй 28.1 хувь буюу 55 барилга, байгууламжийг тусгасан байна.

Хүснэгт 3. Шинээр эхлүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсөв баталгаажсан байдал /тоо, эзлэх хувь/

Д/д	ТЕЗ	Зураг, төсөв шаардлагатай шинээр хэрэгжих ТАХ-ний тоо	Үүнээс,			
			Хуулийн төсөлд тусгахын өмнө зураг, төсвийг нь батлуулсан ТАХ-ний		Хуулийн төсөлд зураг төсөвгүй туссан ТАХ-ний	
			Тоо	Хувь	Тоо	Хувь
1	ЗТХС	19	13	68.4	6	31.6
2	МУЕС	10	7	70.0	3	30.0
3	ЗГХЭГД	5	5	100.0	0	0
4	ЭХС	12	5	41.7	7	58.3
5	БОАЖС	1	0	0	1	100.0
6	БХС	2	2	100.0	0	0
7	Сангийн сайд	1	1	100.0	0	0
8	ХХААХҮС	8	2	25.0	6	75.0
9	ХНХС	18	12	66.7	6	33.3
10	БХБС	29	9	31.0	20	69.0
11	БШУС	55	52	94.5	3	5.5
12	ХЗДХС	5	5	100.0	0	0
13	ЭМС	21	20	95.2	1	4.8
14	Соёлын сайд	8	6	75.0	2	25.0
15	УЕП	2	2	100.0	0	0
Нийт дүн		196	141	71.9	55	28.1

Эх сурвалж: Үндэсний аудитын газар

4.4 Төсвийн төсөлд зураг төсөвгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг тусгасан нь төсөл, арга хэмжээний гүйцэтгэл удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх, үр ашиг буурах, хуулийн хэрэгжилт хангагдахгүй болох нөхцөлийг бүрдүүлсэн байна.

4.5 Ирэх онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 232 төсөл, арга хэмжээний:

- 35.6 хувь буюу 65.7 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 67 нь дэд бүтцийн салбарын;
- 22.8 хувь буюу 42.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 57 нь цэцэрлэг, сургууль, дотуур байр;
- 5.5 хувь буюу 10.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 21 нь эрүүл мэндийн салбарын;
- 15.5 хувь буюу 28.6 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 51 нь нийгмийн үйлчилгээний;
- 7.5 хувь буюу 13.8 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 17 нь бусад зориулалттай;
- 13.1 хувь буюу 24.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 19 нь конторын барилга байна.

4.6 Төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр тусгасан нийт 4.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 2 сургуулийн барилга, 1 төмөр бетон гүүрийг шинээр барихгүйгээр засварлан сайжруулж, төсвийн хөрөнгийг хэмнэх боломжтой байна.

4.7 Төсвийн ерөнхийлөн захирагчдаар авч үзвэл, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Дэд бүтцийн салбарын ТЕЗ-даас гадна Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Улсын Ерөнхий прокурорын төсвийн багцын хөрөнгийн зардлыг 4.0-17.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөжээ.

4.8 Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д “шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах” гэж заасныг

баримтлахгүйгээр төсвийн төсөлд нийт 15 ТЕЗ-ийн 149 төсөл, арга хэмжээний тухайн онд санхүүжих дүнг хуулийн шаардлагаас 105.7 тэрбум төгрөгөөр дутуу төсөвлөсөн нь хуулиар тодорхойлсон хугацаанд төсөл, арга хэмжээ ашиглалтад орохгүй байх, гүйцэтгэл удаашрах эрсдэлтэй байна. /Хавсралт 1/

4.9 Иймд эдгээр төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хойшлуулах, зайлшгүй хэрэгжүүлэх тохиолдолд тухайн жилд санхүүжүүлэх дүнг хуулийн дээрх шаардлагад нийцүүлэн тусгах нь зүйтэй байна.

4.10 Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хуульд баталснаас хойш улсын комисс ашиглалтад хүлээн авах хүртэл хугацаанд хуулийн нэг дугаараар кодчилоогүйгээс он оны төсвийн тухай хуульд тухайн төсөл, арга хэмжээний хуулийн дугаарыг өөрчлөн баталснаар зарим төсөл, арга хэмжээ орхигдож байгаа нь царцсан барилгууд бий болох эрсдэлийг нэмэгдүүлж байна.

4.11 Төсвийн төсөлд 4 ТЕЗ-ийн төсвийн багцад 5.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй зах зээлийн үнэлгээ хийгдээгүй, төсөвт өртөг тодорхойгүй 4 барилгыг шинээр худалдаж авахаар тусгасан нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлтэй байна. /Хавсралт 2/

4.12 Өмнөх онуудын төсвийн тухай хуульд 12 ТЕЗ-ийн төсвийн багцад батлагдсан үргэлжлэн хэрэгжих 106 төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгахдаа 215.6 тэрбум төгрөгөөр төсөвт өртгийг нэмэгдүүлсэн байна. Үүний 45.3 хувь буюу 48 төсөл, арга хэмжээг хуульд зураг төсөвгүй баталснаас, 24.5 хувь буюу 26 төсөл, арга хэмжээний гадна инженерийн шугам, сүлжээний ажлын зардлыг төсөвт тусгаагүйгээс, 15.1 хувь буюу 16 төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээнд өөрчлөлт орсноос, 6.6 хувь буюу 7 төсөл, арга хэмжээний анхны зураг төсөвт дахин магадлал хийгдсэнээс, 8.5 хувь буюу 9 нь бусад шалтгаантай байна.

4.13 Төрийн байгууллагууд гэрээний үүргээ хэрэгжүүлээгүйгээс ашиглалтад орсон болон 90 буюу түүнээс дээш хувийн гүйцэтгэлтэй 25 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтэд төсвийн төсөлд хөрөнгө тусгаагүй, заримд нь 50.0 сая төгрөгийн санхүүжилтийг төлөвлөсөн нь гүйцэтгэгч аж ахуйн нэгжид санхүүгийн хүндрэл учруулах, төсөл, арга хэмжээний үр ашгийг бууруулах эрсдэлийг бий болгосон байна. /Хавсралт 3/

Дүгнэлт

- Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн талаарх эрх зүйн зохицуулалтыг хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх зарчимд нийцүүлэх шаардлагатай байна.
- Төсвийн төсөлд зураг төсөвгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг тусгасан нь салбарын бодлого алдагдахад хүргэх, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх, үр ашиг буурах, хуулийн хэрэгжилт хангагдахгүй болох нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- Сангийн яамнаас сүүлийн 2 жилийн хугацаанд улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн аргачлалыг баримтлах, олон улсын жишигт нийцүүлэх, мөн хэрэгжилт, санхүүжилтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг нэвтрүүлэн хэрэгжүүлж байгаа боловч төлөвлөлтийн шатанд бүрэн хэрэгжүүлэхгүй байгаад бүх түвшинд анхаарч ажиллах шаардлагатай байна.

КОНЦЕССЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ТАЛААР:

4.14 Төсвийн төсөлд концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эргэн төлөлтийг Шадар сайдын төсвийн багцад Төрийн худалдан авах ажиллагааны газар хариуцан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

4.15 Монгол Улсын 2021 оны төсвийн төсөлд концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн нийт 849.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төслийн эргэн төлөлтөд 224.9 тэрбум төгрөгийг олгохоор төсөвлөжээ.

4.16 Концессын 2014-2017 онд байгуулсан гэрээний үнийг гадаад валютаар төлөхөөр тусгаснаас шалтгаалан 2021 онд эргэн төлөлт хийгдэх “Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай автозам” төсөл 14.7 тэрбум, “Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай автозам” төсөл 12.6 тэрбум төгрөгийн ханшийн өөрчлөлтөөр төсөвт өртөг нь тус тус нэмэгдсэн байна.

Дүгнэлт

- Төрөөс концесс эзэмшигчидтэй “барих-шилжүүлэх” төрлөөр байгуулсан Гэрээнд төслийг улсын комисс байнгын ашиглалтад хүлээн авсан эсвэл өмчлөлийг шилжүүлсэнтэй нь хамааруулан эргэн төлөлт хийх хугацааг тусгадаггүйгээс хөрөнгө оруулалтын төсвийн төлөвлөлт хийхэд төсөл, арга хэмжээний эргэн төлөлт орхигдох, илүү дутуу төсөвлөгдөх, төсөвт батлагдсан хөрөнгийг ашиглахгүй байх эрсдэлтэй байна.
- Концессын төслүүдийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдаагүй байхад гэрээ байгуулсан, эргэн төлөлтийг гадаад валютаар төлөхөөр тусгасан, төслүүдийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй, тулгамдсан асуудлыг төрөөс шийдвэрлэхэд хугацаа алддаг зэрэг нь төслүүдийн өртөг нэмэгдэх нөхцөл болж, төслийн үр ашгийг бууруулж байна.

ТАВ. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

5.1 Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн төсөлд орон нутгийн суурь орлогыг 1,469.2 тэрбум, суурь зарлагыг 811.6 тэрбум, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг 162.9 тэрбум, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 533.6 тэрбум төгрөгөөр тус тус төсөвлөсөн байна.

5.2 Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсөвт орон нутгийн төсвийн суурь зарлагыг 2,701.9 тэрбум төгрөгөөр тогтоосныг орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 3,229.1 тэрбум төгрөг болгож, 527.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

5.3 Нийслэл, дүүргүүдийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албадын 6-11 орон тоог 2012 оноос хойш нэмэгдүүлж, албан тушаалын чиг үүрэг тодорхойгүй 45-66 орон тоотойгоор ажилладаг бөгөөд шат шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөд урамшуулал олгодог, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нар 2-4 орлогч, орон тооны зөвлөхүүд ажиллуулдаг, төсвөөс санхүүжүүлдэг орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг байгуулсан зэргээр урсгал зардлыг нэмэгдүүлж байна.

5.4 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 220.7 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн нь өмнөх оноос 48.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

5.5 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зориулалт бус, үр ашиггүй зарцуулдаг зөрчил арилахгүй байна.

Дүгнэлт

- Орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хянасан төсвийн суурь зарлагыг нэмэгдүүлэхдээ үр ашиггүй зардлыг баталж байгаа нь нэгдсэн төсвийн бодлого, зарчмыг алдагдуулж байна.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг иргэдийн саналд үндэслэн тухайн орон нутгийн онцлогт нийцсэн хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг бүсчлэн байгуулах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд чиглүүлэх шаардлагатай байна.

ЗУРГАА. НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ

6.1 Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2,153.7 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 5.1 хувьтай тэнцүү байхаар төлөвлөсөн байна.

6.2 Засгийн газар дотоод үнэт цаас гаргаж 2,166.0 тэрбум, гадаад төслийн болон хөтөлбөрийн зээлээс 1,561.1 тэрбум, Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдлээс 156.0 тэрбум, харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдлээс 150.9 тэрбум төгрөг, нийт 4,034.0 тэрбум төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр төлөвлөжээ.

6.3 Дээрх эх үүсвэрээс Засгийн газрын дотоод үнэт цаасны үндсэн төлбөрт 569.6 тэрбум, гадаад үнэт цаасны төлбөрт 392.4 тэрбум, гадаад төслийн зээлийн эргэн төлөлтөд 918.3 тэрбум, нийт 1,880.3 тэрбум төгрөгийг зарцуулж, үлдэх 2,153.7 тэрбум төгрөгөөр нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэхээр тооцсон байна.

6.4 Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөлд улсын төсвийн тэнцлийг 1,911.1 тэрбум, нийгмийн даатгалын сангийн төсвийн тэнцлийг 91.7 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн тэнцлийг 150.9 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар /нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын сангийн зардлын эх үүсвэрт Капитал банкнаас авах 240.1 тэрбум төгрөгийн авлагыг эргэн төлөгдөхөөр/ төлөвлөжээ.

Дүгнэлт

- Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2,153.7 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 5.1 хувьтай тэнцүү байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасантай нийцэж байна.
- Цаашид жилийн төсвийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлага болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөхгүйгээр боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж хэвших, төсвийн төлөвлөлтийн сахилга батыг сайжруулах шаардлагатай байна.

ДОЛОО. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГА

7.1 Төсвийн төсөлд тусгасан Засгийн газрын өр нэрлэсэн дүнгээр 2020 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 28,691.7 тэрбум, 2021 оны эцэст 31,127.6 тэрбум төгрөг буюу ирэх онд Засгийн газрын нийт өр 2,435.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна.

7.2 Өрийг бүтцээр нь авч үзвэл, дотоод өр 3,168.2 тэрбум төгрөг буюу 10.2 хувийг, гадаад өр 26,275.4 тэрбум төгрөг буюу 84.4 хувийг, Засгийн газрын өрийн баталгаа 959.8 тэрбум төгрөг буюу 3.1 хувийг, барих-шилжүүлэх төрлийн концессын өр 724.2 тэрбум төгрөг буюу 2.3 хувийг тус тус эзэлж байна.

7.3 Засгийн газрын нийт өрийн 87.5 хувийг гадаад өр эзэлж буй нь валютын ханшийн эрсдэл өндөр байгааг илэрхийлж байна.

7.4 Эдийн засгийн өсөлт, экспортын орлого уул уурхайн салбараас хэт хамааралтай, эдийн засгийн төрөлжилт багатай Монгол Улсын хувьд нийт өрд эзлэх гадаад өрийн хэмжээ ийнхүү өндөр байгаа нь төсвийн гадаад зах зээлээс хамааралтай байдлыг улам нэмэгдүүлж байна.

7.5 Засгийн газрын өрийн хүү, шимтгэлийн зардалд 2021 онд нийт 1,137.5 тэрбум төгрөг төлөхөөр тусгаснаас 48.0 хувийг гадаад үнэт цаасны хүү, 28.4 хувийг дотоод үнэт цаасны хүү, 23.6 хувийг гадаад зээлийн хүүгийн зардал тус тус эзэлж байна.

7.6 Ирэх онд Засгийн газрын дотоод үнэт цаасны эргэн төлбөрт 569.6 тэрбум, гадаад үнэт цаасны үндсэн төлбөрт 392.4 тэрбум, гадаад зээлийн эргэн төлөлтөд 918.3 тэрбум, хүүгийн зардалд 1,137.5 тэрбум буюу өрийн үйлчилгээний нийт зардалд 3,017.8 тэрбум төгрөг төлөхөөр тооцсон нь нэгдсэн төсвийн нийт орлогын 23.0 хувьтай тэнцэхээр байна.

7.7 Засгийн газар 2012 онд арилжаалсан 5.125 хувийн хүүтэй Чингис бонд, 2016 онд арилжаалсан 10.875 хувийн хүүтэй Мазаалай бондуудын эргэн төлөлтийг хойшлуулж жигдлэх, хүүгийн төлбөрийн дарамтыг бууруулах зорилгоор 5.125 хувийн хүүтэй Номад бондыг Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хүрээнд 2020 оны 10 дугаар сард гаргаснаар 2021 оны гадаад өрийн үйлчилгээний дарамтыг бууруулсан байна.

Дүгнэлт

- Өрийн үйлчилгээний төлбөрийн төсөвт ирэх ачааллыг бууруулах арга хэмжээг “Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг”-ийн хүрээнд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахдаа Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай хуульд заасан нийгмийн халамжийн болон хөрөнгө оруулалтын зардлын дүнг өөрчилсөн боловч орлого, зарлага, алдагдал, Засгийн газрын өрийн хэмжээг нэмэгдүүлэхгүй тооцсон байна. Цаашид жилийн төсвийн төслийг боловсруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд бүрэн нийцүүлж байх нь зүйтэй байна.
- Эрүүл мэндийн салбарт иргэнээ дагасан, гүйцэтгэлд суурилсан санхүүжилт олгох, мөн боловсролын салбарт төсвийн санхүүжилттэй холбоотой цахим шинэчлэлүүдийг эхлүүлэхээр байгаа нь төсвийн удирдлагын оновчтой тогтолцооны эхлэл болохоор байна.
- Төрийн байгууллагуудын бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг татварын цахим төлбөрийн баримтын системд бүрэн холбож, цахимжуулан татварын орлогыг нэмэгдүүлэх боломж байна.
- Төсвийн төсөлд халамжийн зардлыг өмнөх оны төлөвлөсөн дүнгээс бууруулж байгаа ч цаашид халамжийн бодлогыг тэлэхгүй байх, нэр төрлийг нэгтгэн шалгуур үзүүлэлт, аргачлалыг оновчтой болгож, зорилтот бүлэгт чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж, төсвийн үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.
- Төсвийн байгууллагын сургалт семинар, хурал зөвлөгөөн, гадаад дотоод албан томилолтыг цахимаар зохион байгуулан, төрөөс иргэд, аж ахуйн нэгжүүдэд үзүүлдэг бүх төрлийн үйлчилгээ, тусгай зөвшөөрөл олголт, халамжийн цахим системийг бий болгож зардлыг бууруулах боломжтой байна.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг иргэдийн саналд үндэслэн тухайн орон нутгийн онцлогт нийцсэн хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг бүсчлэн байгуулах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд чиглүүлэх шаардлагатай байна.
- Төсвийн төсөлд хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх 55 барилга, байгууламжийн зураг төсвийг батлуулаагүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй тусгасан нь төсөл, арга хэмжээний гүйцэтгэл удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх, үр ашиг буурах, хуулийн хэрэгжилт хангагдахгүй байгааг анхаарч, төсвийн төлөвлөлтийн хариуцлагын талаарх эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.
- Дэлхий нийтийг хамарсан цар тахлын эрсдэл бүхий нөхцөлд хэрэгжих 2021 оны төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ач холбогдол, зориулалт, хэрэгцээ, шаардлагаар нь эрэмбэлэн санхүүжүүлэх асуудлыг журамлан зохицуулах нь зүйтэй байна.
- Засгийн газрын гадаад өрийн зохистой түвшнийг баримтлах, гадаад зээлээр үр ашиг бүхий төслийг санхүүжүүлэн тогтвортой хөгжих нөхцөлийг бий болгоход хөгжлийн болон төсвийн бодлогыг чиглүүлэх шаардлагатай байна.

Хавсралт 1

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 29.3.5-Д ЗААСАН ШААРДЛАГЫГ ХАНГААГҮЙГЭЭС ДУТУУ ТӨЛӨВЛӨСӨН САНХҮҮЖИЛТИЙН СУДАЛГАА

/сая төгрөг/

№	ТЕЗ	Монгол Улсын 2021 оны төсвийн төсөлд тусгагдсан шинээр эхлэх барилга байгууламж			Тухайн жилд санхүүжилт дутуу төлөвлөгдсөн	
		ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Дутуу санхүүжилтийн дүн
1	МУЕС	10	30,800.0	5,300.0	9	10,475.0
2	ЗГХЭГД	10	22,250.0	6,598.0	3	4,950.0
3	БОАЖС	2	2,500.0	700.0	1	800.0
4	БХС	3	19,846.0	4,600.0	1	6,123.0
5	САНГИЙН САЙД	2	66,140.9	66,140.9		
6	ХЗДХС	5	12,597.8	4,513.9	3	1,785.0
7	ХНХС	18	36,959.7	12,030.4	11	7,200.8
8	БХБС	53	93,161.4	33,042.4	29	12,961.3
9	БШУС	57	131,691.0	40,632.1	44	30,489.5
10	СОЁЛЫН САЙД	9	23,588.5	7,250.0	6	4,644.3
11	ЗТХС	20	62,675.4	19,156.2	13	12,782.6
12	ХХААХҮС	9	18,251.2	7,188.0	4	981.6
13	ЭХС	12	49,117.6	23,217.6	7	2,691.7
14	ЭМС	21	38,167.6	10,065.6	17	9,194.8
15	УЕП	2	9,546.7	8,146.7	1	600.0
	НИЙТ	233	617,293.8	248,581.8	149	105,679.6

Хавсралт 2

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2021 ОНД ХУДАЛДАН АВАХААР ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

/сая төгрөг/

Хуулийн дугаар	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
			Эхлэх	Дуусах		
Шинээр худалдан авах						
X.1.1.17	ХНХС	Хүүхэд, залуучууд, ахмадын хөгжлийн барилга худалдан авах /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг 1, 2, 19, 20 дугаар хороо/	2021	2022	1,600.0	800.0
XII.1.1.235	БШУС	Цэцэрлэгийн барилга худалдан авах, 200 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 4 дүгээр хороо, Ханбогд хотхон/	2021	2022	2,400.0	750.0
XVI.1.19	БШУС	Хүнс, хөдөө аж ахуйн газрын барилга худалдан авах /Хэнтий, Хэрлэн сум/	2021	2021	600.0	600.0
XVIII.1.43	ЭМС	Хавдрын эрт илрүүлгийн төвийн барилга худалдан авах /Хөвсгөл, Мөрөн сум/	2021	2022	1,300.0	300.0
		ДҮН			5,900.0	2,450.0

Хавсралт 3

МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2021 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУСГАГДААГҮЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГС ААЛТ

№	Хуулийн дугаар	ТӨЗ	Төсөл, арга хэлжээний нэр, хүчин чадал, байршил	Хуацаа		Төсөвт өртөг	УЛСЫН ТӨСВИЙН санхүүжүүлэхээр тусгасан дүн	Шардлагатай санхүүжилтийн дүн	Улсын төсвийн 2021 оны төсөлд туссаагүй
				Эхлэх	Дуусах				
1		БШУС	Сургуулийн барилга, 640 суудал, /Увс, Тариалан сум/	2012	2021	5,073.3	-	109.0	Ашиглалтад орсон. Гэрээний үлдэгдэл 109.0 сая төгрөгийг гүйцэтгэгчид олгох тухай Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 18/ШШ.2020/0109С дугаар шийдвэр гарсан.
2		БШУС	Сургуулийн дотуур байрын барилга, 100 ор /Говь, Жаргалант сум/	2019	2021	1,100.С	-	51.5	Ашиглалтад орсон. Гэрээний үлдэгдэл 51.5 сая төгрөгийг 2019 оны жилийн эцэст улсын төсөвт төвлөрүүлсэн.
3		БШУС	Сургуулийн дотуур байрын барилга, 75 ор /Сүхбаатар, Уулбаян сум/	2019	2021	900.0	-	90.1	Гэрээний үлдэгдэл 90.1 сая төгрөгийг 2019 оны жилийн эцэст улсын төсөвт төвлөрүүлсэн.
4		БШУС	Сургуулийн барилгын өргөтгөлийн үлдэгдэл санхүүжилт Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, Амгалан цогцолбор сургууль/	2019	2021	4,568.0	-	241.9	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах 2020.03.15-ны өдрийн 5А-040/2020 дугаар комиссын дүгнэлттэй. Гадна цахилгаан хангамжийн са-хуужилт.
5		БШУС	Сургуулийн барилга, 920 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо/	2019	2021	7,658.0	-	1,872.9	Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны нутаг дэвсгэрт 133 дугаар сургуулийн 920 суудалтай сургуулийн барилга, олон улсын сургалттай 640 суудалтай "Монгол тэмүүлэл" сургууль, 320 ортой цэцэрлэгийн барилга нэг дор хэрэгжиж байна. Энэ барилгын нэмэлт ажлын төсөв, гадна тохижилт-ын ажлын 1872.9 сая төгрөг.
6		БОАЖС	Бөйгөлийн орчин, аялал жуулчлалын газрын конторын барилга /Хөвсгөл, Мөрөн сум/	2012	2017	1,095.0	-	127.3	Цингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 182/ШШ.2020/00943 дугаар шийдвэртэй.
7		БШУС	Сургуулийн барилга, 480 суудал /Улаанбаатар, Сонтинсхайрхан дүүрэг, 20 дугаар хороо/	2019	2020	3,332.0	-	2,526.8	Төсөвт өртөг гадна дугаар шугамын ажил нэмэгдсэнээр 585.18 сая төгрөгөөр магадлал хийгдэж баталгаажсан.
8	IV.1.1.1	ЗГХЭГД	Аймгийн засаг даргын тамгын газрын барилга /Дорнод, Чойбалсан/	2011	2022	6,541.0	50.0	958.6	Ажлын гүйцэтгэл 90-ээс дээш хувьтай
9	XII.1.1.18	БШУС	Дотуур байрын барилга, 100 ор /Хэнтий, Баян-Адрага сум/	2019	2022	1,568.1	50.0	368.1	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах 2020.08.12-ны өдрийн комиссын дүгнэлттэй.
10	XII.1.1.40	БШУС	Сургуулийн барилга, 240 суудал /Хөвсгөл, Эрдэнэбулган сум/	2018	2022	1,336.1	50.0	170.0	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах 2020.02.27-ны өдрийн УИД-2020/03 дугаар комиссын дүгнэлттэй.

11	XII.1.1.52	БШУС	Сүргүүлийн барилга, 320 суудал /Хөвсгөл, Арбулаг сум/	2018	2022	4,179.0	50.0	379.0	Ажлын гүйцэтгэл 95-ээс дээш хувьтай	
12	XII.1.1.72	БШУС	Сүргүүлийн барилга, 928 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Эрдэнэт цэцэрлэг сургууль/	2018	2022	5,632.2	50.0	1,335.0	Ажлын гүйцэтгэл 90-ээс дээш хувьтай	
13	XII.1.1.102	БШУС	Сүргүүлийн барилгын өргөтгөл, 360 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 47 дугаар сургууль/	2018	2022	3,101.0	50.0	201.0	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах 2020.02.05-ны өдрийн 2020/108 дугаар комиссын дүгнэлттэй.	
14	XII.1.1.105	БШУС	Сүргүүлийн барилгын өргөтгөл, 640 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Шавь цэцэрлэг/	2018	2022	4,031.1	50.0	531.1	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах 2019.10.10-ны өдрийн 2019/443 дугаар комиссын дүгнэлттэй.	
15	XII.1.1.107	БШУС	Сүргүүлийн дотуур байрны барилга, 100 ор /Говь-Алтай, Билэр сум/	2019	2022	1,946.5	50.0	846.5	Ажлын гүйцэтгэл 95-ээс дээш хувьтай	
16	XII.1.1.135	БШУС	Цэцэрлэгийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, сувиллын цэцэрлэг, яслийн 10 дугаар цэцэрлэг/	2018	2022	6,818.3	50.0	1,092.1	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах 2020.07.03-ны өдрийн 325/2020 дугаар комиссын дүгнэлттэй.	
17	XII.1.1.137	БШУС	Цэцэрлэгийн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 12 дугаар хороо/	2019	2022	1,674.4	50.0	102.4	Ажлын гүйцэтгэл 95-ээс дээш хувьтай	
18	XII.1.1.139	БШУС	Цэцэрлэгийн барилга буулгаж, барих, 150 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 12 дугаар хороо, 20 дугаар цэцэрлэг/	2019	2022	2,135.5	50.0	577.0	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах 2020 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 363/2020 дугаар комиссын дүгнэлттэй.	
19	XII.1.1.142	БШУС	Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 240 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 50 дугаар цэцэрлэг/	2019	2022	3,519.5	50.0	1,359.3	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах 2019.10.10-ны өдрийн 2019/449 дугаар комиссын дүгнэлттэй.	
20	XII.1.1.163	БШУС	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Орхон, Баян-Өндөр сум, Яргуйт байр/	2018	2022	1,984.6	50.0	384.6	Ажлын гүйцэтгэл 95-ээс дээш хувьтай	
21	XII.1.1.180	БШУС	Цэцэрлэгийн барилга, 260 ор /Баянхонгор, Баянхонгор сум/	2018	2022	3,339.0	50.0	1,289.0	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах 2019.08.22-ны өдрийн №1 дугаар комиссын дүгнэлттэй.	
22	XII.1.1.181	БШУС	Цэцэрлэгийн барилга, 260 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 4 дүгээр цэцэрлэг/	2018	2022	2,292.8	50.0	492.8	Ажлын гүйцэтгэл 90-ээс дээш хувьтай	
23	XII.1.1.187	БШУС	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Баян-Өлгий, Ногооннуур сум/	2018	2022	758.6	50.0	258.6	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах 2019.09.23-ны өдрийн 23/2019 дугаар комиссын дүгнэлттэй.	
24	XVIII.1.9	ЭМС	Сум дундын эмнэлгийн барилга /Дундговь, Эрдэнэдалай сум/	2018	2022	2,200.0	56.0	700.0	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах 2020.01.30-ны өдрийн 01/2020 дугаар комиссын дүгнэлттэй.	
25	XVIII.1.10	ЭМС	Сумын төвийн шинэчлэлт хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эмнэлэг, 100 ор /Дорноговь, Замын-Үүд сум/	2013	2022	8,058.0	50.0	1,702.0	Ажлын гүйцэтгэл 95-ээс дээш хувьтай	
							84,842.0	906.0	17,775.7	
НИЙТ ДҮН										